

Эрхэм Судлагч сурагчийн эцэг эх танаа,

Сүүлийн 18+ сар бүжигнаж өнгөрлөө. Цар тахал нь сургуулийн коммюнитигийн дэмжлэгийн системийн ач холбогдлыг илүү тодорхой харууллаа. Хүүхэд бүрийг аюулгүй, халамжилсан орчинд байлгах сургуулийн коммюнити нь хичээл сурлагаас дутахгүй чухал юм. Discovery нь хүүхдүүдийн хувьд аль хэдийн гайхалтай, дулаан, халамжтай гэр нь болсон бөгөөд анхаарал халамжаа улам нэмэгдүүлэхийн тулд Discovery Elementary нь хүмүүсийн хоорондын ялгааг хүндлэх, бүх түвшинд нэг талыг сахисан үзэл, дээрэлхэх явдалтай тэмцэх, олон янз байдлыг тэмдэглэхэд сургуулиудад дэмжлэг үзүүлэх зорилготой үндэсний хөтөлбөр болох **No Place for Hate®-д (Үзэн Ядах Газар Биш)** дахин оролцох гэж байна.

Нэр Хүнд Гутаах Явдлын Эсрэг Лигийн боловсруулсан No Place for Hate® хөтөлбөр нь бүх хүнийг хүндлэх, тэгш хандах, оролцуулах явдлыг дэмждэг соёлыг тэтгэх зорилготой сурагч, ажилтан, олон нийтийн тавцанг цэцэрлэгийн өмнөхөөс 12-р анги хүртэлх сургуулиудад олгодог ба сургууль дээр хэрэгжиж буй бат бөх нийгэм-сэтгэл зүйн арга ажиллагаатай хослон ажиллана. Багш нар тухайн ангид тохирсон хичээлийн төлөвлөгөөг сургалтын хөтөлбөрт оруулахаар ажиллаж байгаа тул ирэх саруудад танай хүүхэд No Place for Hate® хөтөлбөрийн даалгавруудын талаарх зүйлсийг гэртээ ярьж эхэлж магадгүй. Анги болгон (ангид зурагт хуудас болгон тавих) No Place for Hate-н Амлалтанд “гарын үсэг зурах ёслол”-г хийх ба тус амлалтад дараах зүйлс бичигдсэн байна:

- Би бүх хүнэтэй шударга харьцана гэж амалж байна.
- Над шиг биш байсан ч би бүх хүнтэй эелдэг харьцахыг хичээхээ амалж байна.
- Хэрэв хэн нэгнийг дээрэлхэж гар хүрч байвал би багшид хэлнэ.
- Би бусдыг сургууль дээр аюулгүй, аз жаргалтай байхад нь тусална.
- Би сургуулиа Үзэн Ядах Газар Биш болгоход хувь нэмрээ оруулна.

Үүнээс гадна та No Place for Hate®-г гэртээ зуршил болгож болно! Дээрэлхэх, нэг талыг сахисан үзэлтэй тэмцэх талаарх гэр бүлд суурилсан мэдээллийг дараах хаягнаас авна уу <https://www.adl.org/education-and-resources/resources-for-educators-parents-families>.

Discovery Elementary дээрх No Place for Hate®-д оролцох эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл хөтөлбөрийн талаар асуулт байвал NPFH-н Эцэг эхчүүдийн дарга Лора Соёртой laurasawyerdhokai@gmail.com хаягаар эсвэл NPFH-н Удирдах Багш Доктор Кэйт Рийвстэй keith.reeves@apsva.us хаягаар холбоо барина уу.

Мөн та дараах вебсайтруу зочлон дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой. <https://www.noplaceforhate.org/>. Таны туслалцаатай бид сургуулиа бүгдэд аюулгүй, нээлттэй орчин болгох зорилгынхоо төлөө ажилласаар байх болно.

Хүндэтгэсэн,

Лора Соёр (2-р ангийн Судлагч сурагч Гас Докай-н ээж)